



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар Б/13

Хэрлэн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3 дахь заалт, Архивын ерөнхий газрын даргын 2024 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архивын ерөнхий газраас цахимжуулалт хариуцсан ажилтнуудын орон тоо, цалингийн хэмжээнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан архивын тасгийн цахимжуулалт хариуцсан ажилтан Чулуунбаатарын Болормаа, Эрдэнэцогтын Заяасайхан нарын үндсэн цалинг 827,000 (найман зуун хорин долоон мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчилсэн цалинг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс тооцож олгохыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.

3.Албан хаагчдын цалингийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Ч.Баярцолмон)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА